

ХҮҮХДЭД МОРЬ УНУУЛАХ ЗАН ҮЙЛ

(тэмдэглэл⁰)

Ц.Баттулга

Монгол Улсын Их Сургууль, Монгол хэл соёлын сургууль, Түрэг судлалын тэнхим
ts_battulga@yahoo.com

Түлхүүр үг: Хүүхдэд морь унуулах өдөр товлох, морь унах, айл хэсэх, найр хийх

Монголчуудын морьтой холбогдох зан үйл нэн арвин болохыг домог, үлгэр, тууль хийгээд эртний бичгийн сурвалж, зан үйлийн эх хэрэглэгдэхүүний олон мэдээ баримт гэрчилдэг билээ.

Морьтой холбогдох нэгэн өвөрмөц зан үйл Алтайн Урианхайчуудын дунд байсныг товч өгүүлэхийг хичээв.

Алтайн Урианхайчууд МНТ, Судрын чуулган зэрэг түүхэн сурвалж бичгүүдэд дурдагдсан язгуур монгол аймгийн нэг мөн бөгөөд угсаа гарал, зан үйлийнх нь талаар манай эрдэмтэд судалгааны хэд хэдэн бүтээл туурвижээ¹.

Хүүхдэд морь унуулах зан үйл монголын бусад овог ястан, нутаг зоны дунд байж магад. Манай эрдэмтдийн цуглуулсан угсаатны зүйн эх хэрэглэгдэхүүн, бичиж туурвисан эрдэм шинжилгээний бүтээлд эл зан үйлийн талаар тодорхой өгүүлснийг бид хараахан олж үзсэнгүй.

Алтайн Урианхайчууд эрэгтэй хүүхдийг 5,7,9 гэх мэт сондгой настайд, голдуу зун, намрын сард морь унуулдаг байжээ. Морь унуулах сайн өдрийг товлож, аль зүг гарч ямар зүгээс ирэх өлзийтэй болохыг ламаас асуун тодруулдаг байна.

Шулуун зүсмийн /голдуу цагаан/ морь унуулахыг эрхэмлэдэг бөгөөд зориулан төхөөрсөн шинэ эмээл /эрвээлж/ тохож өгөх ба мориний толгой, хондлойд сүү дусаан замд гарахад ээж нь сүү амсуулж, сан тавьж, цацал өргөдөг байжээ.

Аав, зарим тохиолдолд нагац нь дагуулж явах бөгөөд айлууд нохой хорьж, түшиж буулган чөдөр, ногт, хом, цулбуур зэрэг морь, адууны холбогдолт эд зүйл бэлэглэх ба орой нар жаргахаас өмнө ирж хүүхэд морь унуулсаны найр хийдэг уламжлалтай байна.

Хүүхдийг нутгийн хүмүүстэй танилцуулах, нүүр хагарах, нутаг үзүүлэх зэрэг олон зүйл ач холбогдолтой зан үйл байсан бололтой.

Энэ нь морь анх унуулж буй хэрэг огт биш эрт цагт "...ere-yin egem-tür aqta-yin qarqam-tur güргеjü..."² асан нуган хүүхдэд холбогдох ёс байсан мэт.

Хэдийгээр хүүхэд морь унаж сурсан ч эл зан үйл гүйцэтгэдэг байсан нь түүний нуталгаа гэлтэй. МНТ³ны 61 дүгээр зүйлд "yisügei-ba'atur temüjin-ni yisün nasutu бүкүй-түр hö'elün-eke-yin törgüt olqunu'ut irgen-tür naqacu-nar-aca inu öki quyusu ke'en temüjin-ni abu'at yorciba"³ хэмээн гарах бөгөөд Дэй цэцэнтэй

⁰ Цээж эрдэмт, цэцэн билигт нутгийн өвгөдөдөө залбирмуу. Нэгэн намар Саргайн голд, манайд нутгийн өвгөд цуглан хуучлахад хүүхдэд морь унуулах зан үйл одоо мартагдсан тухай хэлэлцэж байсан сан. Хожим ааваас тэмдэглэж авсан зүйл хувийн цуглуулгад буй.

¹ Нямбуу Х, Монголын угсаатны зүй. Улаанбаатар, 1992, 123-125 дугаар тал.
Монгол улсын угсаатны зүй 2. (Ойрадын угсаатны зүй) Улаанбаатар, 1996, 272-332 дугаар Баатар Ц, Гантулга Ц, Алтайн Урианхайн угсаа гарал, түүхийн асуудал. Өлгий, 1990
Гантулга Ц, Алтайн Урианхайчууд. Улаанбаатар, 2000

² Rachewiltz I. De , Index to the Secret History of the Mongols. Uralic and Altaic Series 121. Bloomington, 1972, pp. 151, § 254

³ Rachewiltz I. De , Index to the Secret History of the Mongols. Uralic and Altaic Series 121. Bloomington, 1972, pp. 24-25

харгалдан тэднийд одож сүй талбиж буй зан үйл тодорхой тэмдэглэгдсэн байдаг билээ. Алтайн Урианхайчуудын хүүхдэд морь унуулах зан үйл, магадгүй МНТ-нд өгүүлэгдсэн, эхийн эрхт ёсны үлдэл болох хүргэдэд талбиж зан үйлийн үлдэц, түүний улбаа байхыг үгүйсгэх аргагүй юм.

Нөгөө талаар "hö'elün-eke-yin törgüt olqunu'ut irgen-tür naqacu-nar-aca inu öki quyusu ke'en temüjin-ni abu'at yorcib" хэмээх хэллэг ч аман мэдээтэй дүйж⁴ байна.

Ном зүй

Цэвээн Ж, Дархад, Хөвсгөл нуурын Урианхай, Дүрвэд, Хотон, Баяд, Өөлд, Мянгад, Захчин, Торгууд, Хошууд, Цахар, Дарьганга, Алтайн Урианхай, Хасаг, Хамиганы гарал үүсэл, байдлын өгүүлэл. Улаанбаатар, 1932

Нямбуу Х, Монголын угсаатны зүй. Улаанбаатар

Монгол улсын угсаатны зүй 2. (Ойрадын угсаатны зүй) Улаанбаатар, 1996

Баатар Ц, Гантулга Ц, Алтайн Урианхайн угсаа гарал, түүхийн асуудал.

Өлгий, 1990

Гантулга Ц, Алтайн Урианхайчууд. Улаанбаатар, 2000

Rachewiltz I. De , Index to the Secret History of the Mongols. Uralic and Altaic Series 121. Bloomington, 1972

Лхагвасүрэн И, Алтайн Урианхайн дунд (Ховд, Баян-Өлгийн) явуулсан

угсаатны зүйн хээрийн шинжилгээний ажлын тайлан. (1986-1989 онуудын тайлан) ШУА-ын Түүхийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг.

Хувийн цуглуулгад буй аман зохиол, угсаатанзүйн эх хэрэглэгдэхүүн.

Abstract

Ts. Battulga

Children horse-riding custom

The author wrote about the children horse-riding customs among Altai-Uriankhai. He considered that this custom might be the remains of some traditions which written in the Secret History of Mongols.

⁴ Жаргалын Мишиг (Алтайн урианхайн Зүүн амбан Гонзгой /Чимэддорж/ суманд) өвгөн, Намайг нагац ах маань моринд мордуулж эхлээд гэртээ оруулж билээ. Тэгэхэд аав дагаж явсан юм. Нагацынд очсоны дараа айл хэсэж явсаар нэг мэдэхэд би ядраад үүргэлж байсан санагдана. Айлд хэсэг зуур унтуулаад цааш явсаар гэртээ харьж билээ гэж хуучилж байлаа. Чухам тэр үед ямар зүсмийн морь унаж явсныг бид тэмдэглэж аваагүй байна. // Хувийн цуглуулгад буй.